



# НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД САНАЛ ДҮГНЭЛТ ӨГӨХ

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ОРЛОГЫГ 941.5 СЯЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЭХ, ТӨСВИЙН ЗАРЛАГЫГ 441.9 СЯЯ, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ЗАРЛАГЫГ 592.7 СЯЯ ТӨГРӨГӨӨР БУУРУУЛАХ БОЛОМЖ БАЙНА

АУДИТЫН КОД: ӨВА-2025/07-14-ШТА-НА

Өвөрхангай аймаг 2025 он



Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал

Утас: 7032-3253 Цахим хаяг: [BatjargalO@audit.gov.mn](mailto:BatjargalO@audit.gov.mn)

Аудитын менежер П.Хорлоосүрсэн

Утас: 7032-3108 Цахим хаяг: [KhorloosurenP@audit.gov.mn](mailto:KhorloosurenP@audit.gov.mn)

Ахлах аудитор: Б.Эрдэнэцэцэг

Утас: 7032-3108 Цахим хаяг: [Erdenetsetsegb@audit.gov.mn](mailto:Erdenetsetsegb@audit.gov.mn)

Ахлах аудитор: С.Шийлэгмаа

Утас: 7032-3833 Цахим хаяг: [Shiilegmaas@audit.gov.mn](mailto:Shiilegmaas@audit.gov.mn)

Ахлах аудитор: Ө.Ринчинмядаг

Утас: 7032-3833 Цахим хаяг: [Rinchinmyadagu@audit.gov.mn](mailto:Rinchinmyadagu@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу: Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

## АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ .....	2
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ .....	2
ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ .....	2
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ.....	3
БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХДАА ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ЖУРМЫН ЗАРИМ ЗААЛТТАЙ БҮРЭН НИЙЦҮҮЛЭЭГҮЙ БАЙНА. ....	6
БҮЛЭГ 2. ТАТВАРЫН АВЛАГЫГ БАРАГДУУЛСНААР ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫГ 941.5 САЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ БАЙНА. ....	8
2.1 Газрын төлбөрийн орлого.....	9
2.2 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар .....	10
2.3 Татварын бус орлого буюу Торгуулийн орлого .....	10
БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ЗАРЛАГЫГ ӨМНӨХ ОНООС 35.3 ХУВИАР БУУРУУЛЖ БАТАЛСАН Ч ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭ БОЛОН УРСГАЛ ЗАРДЛЫГ 441.9 САЯ ТӨГРӨГӨӨР БУУРУУЛАХ БОЛОМЖТОЙ БАЙНА. ....	11
БҮЛЭГ 4. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ НЬ ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ЖУРМЫН ЗААЛТТАЙ НИЙЦЭХГҮЙ БАЙНА. ....	14
4.1. Орон нутгийн хөгжлийн сан .....	15
4.2. Авто замын сан.....	18
ДҮГНЭЛТ.....	19
ЗӨВЛӨМЖ .....	20
Хавсралт-1 .....	21
Хавсралт-2 .....	22
ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ .....	23

**ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ**

<b>ААН</b>	Аж ахуйн нэгж
<b>АДБОУС</b>	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
<b>БОХНСАХ</b>	Байгаль орчин хамгаалах
<b>ЕБС</b>	Ерөнхий боловсролын сургууль
<b>ЗДТГ</b>	Засаг даргын тамгын газар
<b>ИТХ</b>	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
<b>МУЗГ</b>	Монгол улсын засгийн газар
<b>ОНХС</b>	Орон нутгийн хөгжлийн сан
<b>СЯ</b>	Сангийн яам
<b>ТАХ</b>	Төсөл, арга хэмжээ
<b>ТЕЗ</b>	Төсвийн ерөнхийлөн захирагч

**ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ**

Хүснэгт 1. 2023-2025 оны аймгийн төсөв .....	5
Хүснэгт 2. Өвөрхангай аймгийн төсвийн нийт орлого, зарлагын хязгаар.....	6
Хүснэгт 3. Хөтөлбөр болон төсөв .....	7
Хүснэгт 4. Аймгийн 2026 оны төсөв дэх суурь орлогын харьцуулалт /сая.төг/ .....	8
Хүснэгт 5. Орон нутгийн орлого нэмэгдүүлэх санал /сая.төг/ .....	8
Хүснэгт 6. Газрын төлбөрийн барагдуулаагүй үлдэгдэл. /мянган.төгрөг .....	9
Хүснэгт 7. Үл хөдлөх, эд хөрөнгийн албан татварын өрийн үлдэгдэл /сая.төгрөг/ .....	10
Хүснэгт 8. Торгуулийн орлогын төвлөрүүлэгч байгууллагуудаас илүү, дутуу төвлөрүүлсэн байдал .....	11
Хүснэгт 9. Бүтэц орон тоо, цалингийн сангийн харьцуулалт.....	12
Хүснэгт 10. Аймгийн 2026 онд ОНХС, авто замын сангаас төлөвлөсөн ТАХ.....	14
Хүснэгт 11. 2023-2025 оны орон нутгийн хөрөнгө оруулалтын тоон үзүүлэлт /сая.төг/.....	15
Хүснэгт 12. Аймгийн ОНХС-с хэрэгжүүлэх “Төсвийн хөрөнгө оруулалтаар 2027 онд баригдах барилга байгууламжийн зураг төсөв боловсруулах” ажлын задаргаа .....	16
Хүснэгт 13. Аймгийн Автозамын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-ний жагсаалт .....	18

**ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ**

Дүрслэл 1. ТЕЗ-н зарлага ангиллаар .....	12
------------------------------------------	----

**АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ**

<b>Аудит нэр:</b>	<b>Өвөрхангай аймгийн 2026 оны төсвийн төсөлд санал дүгнэлт өгөх</b>
<b>Аудитын код:</b>	<b>ӨВА-2025/07-14-ШТА-НА</b>
<b>Аудит хийх бүрэн эрх, үндэслэл:</b>	<p>Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаал, “Эрх шилжүүлэх тухай” Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/102 дугаар тушаалуудыг тус тус үндэслэн Өвөрхангай аймаг дах Төрийн аудитын газар аудитыг хийж гүйцэтгэв.</p> <p>Аймгийн Засаг даргаас иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн аймгийн 2026 оны төсвийн төслийг улсын болон аймгийн бодлогод нийцүүлж, төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглүүлэн боловсруулсан эсэхэд санал, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж холбогдох албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.</p> <p>Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:</p>
<b>Аудитын зорилт:</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Орон нутгийн 2026 оны төсвийн төслийг холбогдох хууль, журамд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулж, төсвийн төслийн тэнцвэржүүлсэн тэнцэл (ашиг, алдагдал)-ийг үндэслэлтэй тооцсон эсэх;</li> <li>• Төсвийн төсөлд тусгагдсан хөрөнгө оруулалтууд нь аймгийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигтэй уялдсан, иргэд, олон нийтийн санал авсан, төлөвлөлтийн шаардлага хангасан эсэх;</li> <li>• Төсвийн орлогыг бодит тооцоо, судалгаанд үндэслэн, эдийн засгийн үндсэн үзүүлэлтэд тулгуурлан аймгийн татварын орлогын үр ашиг, үр нөлөөг нэмэгдүүлэх чиглэлээр үндэслэлтэй төлөвлөсөн эсэх;</li> <li>• Төсвийн урсгал зарлагыг үр дүнд суурилсан арга аргачлалаар, хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөсөн эсэх;</li> </ul>
<b>Аудитын хамарсан хүрээ:</b>	<p>Өвөрхангай аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын хэлтэс, аймгийн Засаг даргын дэргэдэх агентлагуудыг аудитад хамрууллаа.</p> <p>Аймгийн Засаг даргаас аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн 2026 оны төсвийн төсөл, 2023, 2024, 2025 оны батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэл холбогдох нотлох баримтууд болон тооцоо, судалгаанд үндэслэн аудитыг хийж гүйцэтгэлээ.</p>

**Аудитад хэрэглэсэн арга зүй:**

Аудитыг АДБООУС 100, 400, 4000-4200, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-4:2020, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2022 оны А/67 дугаар тушаалаар баталсан “Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аргачлал” болон бусад заавар, аргачлалын дагуу аудитын зорилго, зорилт, хөтөлбөр горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга, судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

**Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:**

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Газрын тухай хууль
- Газрын төлбөрийн тухай хууль;
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль
- Орон нутгийн ТЕЗ нарын 2026 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамж
- Сангийн Сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”
- МУЗГ-ын 2023 оны 278 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”
- Сангийн Сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”
- Сангийн Сайдын 2019 оны 312 дугаар тушаалаар батлагдсан “Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам”
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн акт, стандарт

**Аудитын явцад тулгарсан хүндрэлтэй асуудал:**

Аймгийн ЗДТГ-ийн хэлтсүүдээс шаардлагатай мэдээ, судалгаа, тоо баримтыг шаардсан хугацаанд иж бүрэн, үнэн зөв гаргаж ирүүлэхгүй байгаа нь аудитын санал дүгнэлт гаргахад хүндрэлтэй байсан.

**Үндсэн мэдээлэл:**

Аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 15/06, 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 23/14, 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 02/12 дугаар тогтоолуудаар 2023-2025 оны аймгийн төсвийг дараах байдлаар баталсан байна. Үүнд:

**Хүснэгт 1. 2023-2025 оны аймгийн төсөв**

№	Үзүүлэлт	2023 он	2024 он	2025 он
1	Аймгийн төсвийн орлогын нийт дүн /Аймгийн төсвийн татварын болон татварын бус орлого/	5,909.33	6,861.4	7,553.13
2	Аймгийн төсөвт Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	19,278.1	33,070.47	36,362.01
3	Сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх	2,272.17	4,092.39	8,294.14
4	Аймгийн орон нутгийн хөгжлийн санд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлэг	9,808.2	13,854.94	17,299.86
5	ТЕЗ, түүний харьяа байгууллага, бусад байгууллагын төвлөрүүлэх орлого /Аймгийн орон нутгийн төсвийн байгууллагуудын өөрийн орлого/	267.48	302.0	322.0
6	Аймгийн төсвийн он дамжих үлдэгдлээс санхүүжих дүн	1,000.0	1,012.19	465.01
<b>Аймгийн 2025 оны төсвийн санхүүжүүлэх нийт эх үүсвэр</b>		<b>38,535.28</b>	<b>59,193.39</b>	<b>70,296.15</b>
1	Төсвийн ерөнхийлөн захирагчийн зарцуулах нийт зарлага	16,931.90	23,805.10	30,749.51
2	Аймгийн төсвөөс сумын төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	11,795.15	21,533.36	22,246.78
3	Аймгийн ОНХС-аас сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлэг	5,357.86	8,852.09	11,253.11
4	Аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ зардал	4,450.37	5,002.84	6,046.75
<b>Аймгийн 2025 оны төсвийн нийт зардлын дүн</b>		<b>38,535.28</b>	<b>59,193.39</b>	<b>70,296.15</b>

Дээрх хүснэгтээс харахад 2024 онд өмнөх оноос 34.9 хувийн өсөлттэй, 2025 онд өмнөх оноос 15.8 хувийн өсөлттэй дүнгээр аймгийн төсвийг баталсан байна. Эх үүсвэрийн хувьд татварын болон татварын бус орлого жигд өсөлттэй байсан бол сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлого 2025 онд илүү өсөлттэй, аймгийн орон нутгийн төсвийн байгууллагуудын өөрийн орлого бага хэмжээний өсөлттэй байжээ.

Тухайн онуудад аймгийн төсвөөс сумын төсөвт олгох санхүүгийн дэмжлэг 2024 он хамгийн их өсөлттэй байсан нь төрийн албан хаагчдын цалин нэмэгдсэнтэй холбоотой бусад зардлуудын хувьд тогтмол өсөлттэй байжээ.

Хөрөнгө оруулалтын зардлуудаас 2023-2025 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон их засварын зардал 2024 онд 48.0 хувийн өсөлттэй байсан бол бусад зардлууд тогтмол өсөлттэй байсан байна.

**Өвөрхангай аймгийн 2026 оны төсвийн төсөлд:**

- Суурь орлогыг 37.9 сая төгрөгөөр төлөвлөснөөс сангийн яамны хянасан төсөвт 41.5 сая;
- Суурь зарлагыг 86.7 сая төгрөгөөр төлөвлөснөөс 64.4 сая төгрөг болгон бууруулан хянасан байна.

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ОРЛОГЫГ 941.5 САЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЭХ, ТӨСВИЙН ЗАРЛАГЫГ 441.9 САЯ, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ЗАРЛАГЫГ 592.7 САЯ ТӨГРӨГӨӨР БУУРУУЛАХ БОЛОМЖ БАЙНА.**

**БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХДАА ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ЖУРМЫН ЗАРИМ ЗААЛТТАЙ БҮРЭН НИЙЦҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.**

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1-д заасны дагуу аймгийн Засаг дарга 2026 оны жилийн төсвийн төслийн саналаа 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 01/589 дугаар албан бичгээр хуулийн хугацаанд ирүүлсэн.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.4 “санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Засгийн газрын баталсан жилийн төсвийн хязгаарыг төсвийн удирдамжийн хамт жил бүрийн 7 дугаар сарын 5-ны дотор төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх” гэж заасны дагуу Сангийн яамнаас орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2026 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамж болон төсвийн хязгаарыг ирүүлсэн байна. Өвөрхангай аймгийн төсвийн нийт орлого, зарлагын хязгаарыг дараах байдлаар тогтоожээ.

*Хүснэгт 2. Өвөрхангай аймгийн төсвийн нийт орлого, зарлагын хязгаар.*

№	Үзүүлэлт	Төсвийн хязгаар	Хүргүүлсэн санал	Зөрүү
1	<b>Төсвийн нийт орлогын дүн</b>	<b>79,890.40</b>	<b>99,402.03</b>	-19,511.6
1.1	Үүнээс: Суурь орлогын дүн	55,092.80	37,921.80	17,171.0
1.2	Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	7,497.70	48,818.83	-41,321.1
1.3	Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	17,299.90	12,661.40	4,638.5
2	<b>Төсвийн нийт зарлагын дүн</b>	<b>79,890.30</b>	<b>99,402.03</b>	-19,511.7
2.1	Үүнээс: Суурь зарлагын дүн	62,590.40	86,740.63	-24,150.2
2.2	Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	17,299.90	12,661.40	4,638.5

Дээрх хүснэгтээс харахад Сангийн яаманд хүргүүлсэн төсвийн төслийн орлого, зарлагын дүн төсвийн хязгаарт багтаагүй Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.3-т “жилийн төсвийн хязгаарт багтаасан байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Төсвийн төслийг Орон нутгийн ТЕЗ-ийн 2026 оны төсвийн төсөл бэлтгэх Сангийн яамны удирдамж, төсвийн төслийн танилцуулгыг Төсвийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.2.<sup>1</sup>-д заасны дагуу тус тус бүрэн боловсруулаагүй байна.

<sup>1</sup> 67.2. Орон нутгийн төсвийн төслийн танилцуулгад энэ хуулийн 32.2.1-32.2.12, 32.2.19, 32.2.20-д зааснаас гадна дараах зүйлийг тусгана:

67.2.1. орон нутгийн төсвийн бодлогын зорилтыг тусгасан дунд хугацааны төлөвлөгөө;

67.2.2. энэ хуулийн 22 дугаар зүйлд заасан төсвийн ангиллын дагуу боловсруулсан төсвийн төслийн тооцоо, танилцуулга;

67.2.3. аймаг, нийслэл, улсын зэрэглэлтэй хотын төсвөөс сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсөвт олгохоор төлөвлөсөн санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлгийн санал;

67.2.4. дээд шатны төсөвт тусган баталсан дээд шатны төсөвт төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ.

Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2-д заасны дагуу 2026 онд орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтээр нийт 22 хөтөлбөрт 28,235.75 сая төгрөгийг зарцуулахаар төсөвлөсөн байна.

*Хүснэгт 3. Хөтөлбөр болон төсөв*

Д/д	Хөтөлбөрийн код	Хөтөлбөрийн нэр	Хөтөлбөрийн төсөв (сая.төг)
1	70105	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	1,674.09
2	70709	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	225.00
3	70106	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	9,549.00
4	70426	Төрийн өмчийг хэрэгжүүлэх	423.44
5	70418	Худалдан авах ажиллагаа	303.88
6	70429	Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдэлийн удирдлага	513.12
7	71411	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	1,161.03
8	71413	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	281.77
9	71403	Ойжуулалт	343.86
10	71902	Нийгмийн халамж	305.42
11	71602	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	1,278.60
12	71701	Биеийн тамир, спорт	1,290.33
13	71702	Соёл урлаг	631.20
14	71802	Ерөнхий боловсрол	304.48
15	71804	Мэргэжлийн боловсрол	1,113.52
16	70801	Мал аж ахуйг хөгжүүлэх	512.94
17	71506	Суурин газрын усан хангамж	300.00
18	70708	Гамшгаас урьдчилан сэргийлэх	700.00
19	72208	Ахмад настны хөгжил, хамгаалал	166.97
20	71101	Автозам	1,115.00
21	70203	Засгийн газрын өрийн үйлчилгээ	1,788.00
22	70503	Орон нутгийн хөгжлийн сан	4,254.09
<b>Дүн</b>			<b>28,235.75</b>

Монгол улсын Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу аймгийн ИТХ-ын 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 09/01 дүгээр тогтоолоор 4 үндсэн зорилтын хүрээнд 131 арга хэмжээг хэрэгжүүлэх “Өвөрхангай аймгийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”-г баталсан бөгөөд энэ нь Өвөрхангай аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтэд нийцжээ.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх...” гэж заасны дагуу аймгийн 2026 оны төсвийн төсөлд аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээнүүдийг тусгасан байна.

Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлагдаагүй байгаатай холбоотойгоор Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлагдаагүй байна.

Цаашид төсвийн төслийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, холбогдох баримт материалыг хуульд заасан хугацаанд бүрэн ирүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

**АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Орон нутгийн 2026 оны төсвийн төслийг Төсвийн тухай хууль, Орон нутгийн ТЕЗ-ийн 2026 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамжийн дагуу иж бүрэн боловсруулаагүй байна.

**БҮЛЭГ 2. ТАТВАРЫН АВЛАГЫГ БАРАГДУУЛСНААР ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫГ 941.5 САЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ БАЙНА.**

Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.3-т зааснаар төсвийн ерөнхийлөн захирагч нь тухайн жилийн төсвийн төслийг Сангийн яамнаас хянан ирүүлсэн хязгаарт багтаан боловсруулахаар заасан.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8-д зааснаар Сангийн яамнаас орлогын доод хязгаарыг хянаж ирүүлдэг. Сангийн яам аймгийн төсөвт 2026 онд улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 22,847.9 сая төгрөг, төсвийн жилийн суурь орлогыг 41,553.4 сая төгрөгөөр хянасныг 46,984.1 сая төгрөг болгон 5,430.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.

Аймгийн 2026 оны төсвийн төсөл дэх суурь орлогыг Сангийн яамны баталсан хязгаартай харьцуулахад дараах байдалтай байна.

*Хүснэгт 4. Аймгийн 2026 оны төсөв дэх суурь орлогын харьцуулалт /сая.төг/*

№	Орлогын нэр төрөл	Сангийн яамны хянасан тоо	2026 оны төлөвлөсөн санал	Зөрүү
1	Нийт орлого ба тусламжийн орлого	41,553.4	46,984.1	5,430.7
2	Төсвийн нийт орлого	41,553.4	46,984.1	5,430.7
3	Татварын орлого	37,916.9	39,432.9	1,516.0
4	Татварын бус орлого	3,636.5	7,551.2	3,914.7

*/Эх сурвалж – СТСХ-ийн ажлын баримтаас/*

Дээрх хүснэгтээс харахад татварын орлогыг 1,516.0 сая, татварын бус орлогыг 3,914.7 сая төгрөгөөр нийт 5,430.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэхээр тооцоолсон байна.

Аймгийн 2026 оны төсөвт төвлөрүүлэх 10,957.3 сая төгрөгийг аймаг, 36,026.9 сая төгрөгийг сумын орлогоос бүрдүүлэхээр төлөвлөжээ. Орлогын төлөвлөлтийг Сангийн яамны хянасан дүнтэй харьцуулбал татварын орлогын доод хязгаарыг баримтлан төлөвлөсөн байна.

Сангийн яамнаас хянасан орон нутгийн 2026 оны төсөвт дараах 3 орлогыг 942.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх саналыг хүргүүлж байна. Үүнд:

*Хүснэгт 5. Орон нутгийн орлого нэмэгдүүлэх санал /сая.төг/*

№	Орлогын нэр	2024 оны гүйцэтгэл	2025 оны хүлээгдэж гүйцэтгэл	Өмнөх онуудын авлага	2026 оны төлөвлөсөн санал	Аудитаар нэмэгдүүлэх санал
1	Газрын төлбөр	1,020.8	1,179.0	991.3	1,368.1	333.1
2	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	-	995.4	1,124.3	1,150.0	395.4
3	Татварын бус орлого-Торгуулийн орлого	-	-	426.6	2,728.0	213.0
<b>НИЙТ ДҮН</b>						<b>941.5</b>

*/Эх сурвалж: СТСХ-ийн ажлын баримт/*

**2.1 Газрын төлбөрийн орлого**

Ашигт малтмал, газрын тосны газрын судалгаагаар Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэрт нийт 26 ААН 17,542.69 га талбайд ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байна. Үүнээс 8 суманд уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа 5, түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа 10 хуулийн этгээдийн зөвшөөрөлгүй ашиглаж байгаа газрыг сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаагүй, газар ашиглах захирамж, шийдвэр гараагүй, газрын төлбөр ногдуулаагүй байна. /Хавсралт-1/

Иймд уул уурхайн болон түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын лиценз бүхий газарт газрын төлбөрийг ногдуулж орон нутгийн орлогыг **199.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой** байна.

Аймгийн Татварын газраас ирүүлсэн газрын төлбөрийн авлагын мэдээллээс үзэхэд авлагын үлдэгдэл 991.3 сая төгрөг байна.

Хүснэгт 6. Газрын төлбөрийн барагдуулаагүй үлдэгдэл. /мянган.төгрөг

№	Сумын нэр	2022-с өмнөх	2022	2023	2024	2025	НИЙТ
1	Арвайхээр	43,599.4	67,479.4	91,714.3	107,884.4	266,091.2	576,768.7
2	Баруунбаян-Улаан	104.9	264.1	413.9	987.4	981.0	2,751.3
3	Бат-Өлзий	835.0	2,039.8	5,083.6	1,853.1	4,331.4	14,142.9
4	Баянгол	184.3	366.2	684.5	1,519.0	2,645.4	5,399.5
5	Баян-Өндөр	74.3	7.9	17.0	156.6	708.2	963.9
6	Богд	546.4	914.6	2,549.9	3,491.0	5,570.1	13,072.0
7	Бүрд	89.5	31.1	99.3	513.4	1,813.6	2,546.9
8	Гучин-ус	11.9	480.5	504.1	848.9	1,675.6	3,521.1
9	Есөнзүйл	27.8	157.3	441.0	1,174.3	3,938.4	5,738.8
10	Зүүнбаян-Улаан	975.6	1,355.8	2,833.5	2,581.0	7,093.7	14,839.7
11	Нарийнтээл	197.9	429.7	591.0	2,208.9	14,506.0	17,933.4
12	Өлзийт	465.6	261.9	1,041.0	1,977.7	2,417.8	6,164.0
13	Сант	74.7	211.7	485.2	721.6	1,480.3	2,973.6
14	Тарагт	298.0	281.9	591.0	1,551.5	9,078.6	11,801.1
15	Төгрөг	112.7	178.1	490.9	503.9	1,661.6	2,947.2
16	Уянга	615.4	22,915.7	11,194.3	21,029.7	37,867.4	93,622.5
17	Хайрхандулаан	208.4	291.2	583.4	1,504.0	4,442.5	7,029.6
18	Хархорин	3,033.1	3,945.8	10,623.3	42,828.7	67,620.5	128,051.4
19	Хужирт	6,321.7	2,452.6	4,014.1	3,321.0	5,841.8	21,951.2
20	Аймгийн төвлөрсөн	59,065.6	-	-	-	-	59,065.6
<b>Нийт дүн</b>		<b>116,842.5</b>	<b>104,065.3</b>	<b>133,955.4</b>	<b>196,656.0</b>	<b>439,765.1</b>	<b>991,284.4</b>

Эх сурвалж: Татварын газраас ирүүлсэн мэдээлэл /2025 оны 10 дугаар сарын байдлаар/

Дээрх судалгаанаас харахад Арвайхээр, Уянга, Хархорин сумдын газрын төлбөрийн өр хамгийн өндөр дүнтэй байна.

Нийт газрын төлбөрийн авлагын 22.5 хувь буюу 223.1 сая төгрөгийг 89 төсөвт болон төрийн өмчит байгууллага, 44.6 хувь буюу 442.0 сая төгрөгийг 258 ААН, 32.9 хувь буюу 326.2 сая төгрөгийг 7,228 иргэн төлөөгүйн улмаас бүрдсэн байна.

Газрын төлбөрийн ногдуулалтад хяналт тавьж, биелэлтийг хангахын зэрэгцээ төсөвт байгууллага болон төрийн өмчит ААН-ийн авлагын 60.0 хувь буюу **133.9 сая төгрөгийг барагдуулах замаар орлогыг нэмэгдүүлэх боломжтой** байна.

## 2.2 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар

Аймгийн Татварын газраас 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар ирүүлсэн үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын авлагын мэдээг сүүлийн найман жилийн үзүүлэлттэй харьцуулан авч үзэхэд, нийт авлагын үлдэгдэл 1,105.8 сая төгрөгт хүрсэн байна.

Хүснэгт 7. Үл хөдлөх, эд хөрөнгийн албан татварын өрийн үлдэгдэл /сая.төгрөг/

Он	Ногдуулалт	Барагдуулалт	Өрийн үлдэгдэл
2018	495.9	419.7	76.2
2019	585.6	576.1	9.5
2020	574.3	548.7	25.6
2021	708.1	661.4	46.7
2022	819.7	791.4	28.3
2023	915.9	783.6	132.2
2024	1,388.1	1,144.4	243.7
2025	1,238.2	694.6	543.6
<b>Нийт дүн</b>	<b>6,725.7</b>	<b>5,619.9</b>	<b>1,105.8</b>

Эх сурвалж: Аймгийн Татварын газраас 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр ирүүлсэн материал

Дээрх хүснэгтээс харахад 2024 оны ногдуулалт өмнөх оноос 472.2 сая төгрөгөөр өссөн нь Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1<sup>2</sup>-д заасны дагуу аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 22/02 тогтоолоор аймгийн нутаг дэвсгэрт орших дараах үл хөдлөх эд хөрөнгийн хувь хэмжээг 2.0 хувиар шинэчлэн тогтоосонтой холбоотой байна.

- Уул, уурхайн зориулалтаар ашиглагдаж буй үл хөдлөх эд хөрөнгө
- Цахилгаан, дулаан эрчим хүч үйлдвэрлэх, түгээх болон дамжуулах зориулалтаар ашиглагдаж буй үл хөдлөх эд хөрөнгө
- Бусад татварын албадад үндсэн бүртгэлтэй Өвөрхангай аймагт үйл ажиллагаа явуулдаг салбар, нэгжүүдийн үл хөдлөх эд хөрөнгө

Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын өмнөх онуудын төлөөгүй үлдэгдлээс 2018-2022 онд үүссэн 187.5 сая төгрөгийн өрийг **15.0 хувь буюу 28.1 сая төгрөгөөр**, мөн 2023-2025 онд үүссэн 918.3 сая төгрөгийн өрийг 40.0 хувь буюу **367.3 сая төгрөгөөр барагдуулан төсвийн орлогыг нэмэгдүүлэх боломжтой** байна. Хавсралт 2.

## 2.3 Татварын бус орлого буюу Торгуулийн орлого

Өвөрхангай аймгийн хэмжээнд торгуулийн орлого бүрдүүлсэн 16 байгууллагаас дараах 5 байгууллагын торгуулиас 2023 онд 187.9 сая төгрөг, 2024 онд 238.7 сая төгрөг тус тус дутуу төвлөрсөн байна.

<sup>2</sup> Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан үнэлгээнээс аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, улсын зэрэглэлтэй хотын Зөвлөл тухайн хөрөнгийн байршил, зориулалт, хэмжээ, зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн байдлыг харгалзан 0.6-2.0 хувиар тооцож ногдуулна.

**Хүснэгт 8. Торгуулийн орлогын төвлөрүүлэгч байгууллагуудаас илүү, дутуу төвлөрүүлсэн байдал**

Д/Д	Орлого төвлөрүүлэгч байгууллагын нэр	Орлого төвлөрүүлдэг дансны дугаар	2023 он					2024 он			
			Зөрчлийн тоо	Ногдуулсан	Үүнээс			Зөрчлийн тоо	Ногдуулсан	Үүнээс	
					Төвлөрсөн	Илүү	Дутуу			Төвлөрсөн	Дутуу
1	Аймгийн ЗДТГ	100100000988-Өв.Хүү, торгуулийн орлого	28	53.5	49.5		4.2	26	29.2	14.7	14.5
2	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	100100000982-Өв.МХГазар - орлого		0	0			2	3.0	1.5	1.5
3	Аймгийн Татварын газар	100100000952 аймаг, сумдын татварын торгуулийн данс	123	251.8	251.4	0.1	0.4	99	487.2	487.2	0.0
4	Аймгийн Татварын газар	100100000956 аймаг, сумдын татварын алдангийн данс	36	211.0	199.3		11.7	41	255.2	254.0	1.2
5	Цагдаагийн газар	100100000988-Өв.Хүү, торгуулийн орлого, 100100000985-Өв.ЦХ-н хүү торгуулийн орлого	47,960	1,365.2	1,193.4		171.8	39,518	1,028.0	806.5	221.5
<b>Нийт дүн</b>			<b>48,147</b>	<b>1,881.5</b>	<b>1,693.6</b>	<b>0.1</b>	<b>187.9</b>	<b>39,686</b>	<b>1,802.6</b>	<b>1,563.9</b>	<b>238.7</b>

Эх сурвалж: Төрийн аудитын газраас 2025 онд нэгдсэн удирдамжаар хийгдсэн Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт аудитын тайлан, нэгдсэн судалгаанаас

Дээрх хүснэгтээс харахад дутуу төлөлтийн хамгийн их хэсгийг эзэлж буй Цагдаагийн байгууллагын торгууль нь бэлэн бус байдлаар оногдуулсан торгуулиуд байна.

Өвөрхангай аймгийн хэмжээнд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах эрх бүхий албан тушаалтнуудын ногдуулсан торгуулийн орлого бүрдүүлэлтийн бодит нөхцөл байдлыг судлан, дутуу төвлөрсөн 426.6 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэхтэй холбоотой нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, үүний 50.0 хувь буюу **213.0 сая төгрөгийн авлагыг барагдуулж орлогыг нэмэгдүүлэх боломжтой** байна.

**САНАЛ: Нийт нэмэгдүүлэх боломжтой орлогын хэмжээ 941.5 сая төгрөг**

Газрын төлбөрийг бүрэн ногдуулж 199.2 сая, авлагыг 133.9 сая нийт 333.1 сая төгрөг, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын авлагыг барагдуулж 395.4 сая төгрөг, Татварын бус орлого буюу Торгуулийн орлогын дутуу төвлөрсөн орлогыг 50.0 хувиар 213.0 сая төгрөг, нийт 941.5 сая төгрөгөөр аймгийн төсвийн орлогыг нэмэх санал оруулж байна.

**БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ЗАРЛАГЫГ ӨМНӨХ ОНООС 35.3 ХУВИАР БУУРУУЛЖ БАТАЛСАН Ч ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭ БОЛОН УРСГАЛ ЗАРДЛЫГ 441.9 САЯ ТӨГРӨГӨӨР БУУРУУЛАХ БОЛОМЖТОЙ БАЙНА.**

Аймгийн 2026 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчийн зарцуулах зарлагын дүн 23,981.7 сая төгрөгөөр төлөвлөсөн байна..

Төсвийн ерөнхийлөн захирагчийн зарлагыг 2025 оны төсвөөс 13,089.9 сая төгрөг буюу 35.3 хувиар бууруулж төлөвлөсөн нь Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 20,144.64 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Дүрслэл 1. ТЕЗ-н зарлага ангиллаар



**АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

**1. Төрийн албаны бүтэц бүрэлдэхүүн, хүний нөөцийн өөрчлөлттэй төсвийг хэрхэн уялдуулсан байдал:**

1.1. Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын цалингийн зардлыг төлөвлөхдөө Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай ” Улсын Их Хурлын 54 дүгээр тогтоол”-ын 1 дэх хэсэг, Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд заасны дагуу төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9.0 хувиар бууруулах бодлого, Сангийн Яамны хянасан орон тоо, цалингийн зардалтай уялдуулаагүй байна.

Хүснэгт 9. Бүтэц орон тоо, цалингийн сангийн харьцуулалт

№	Байгууллагын нэр	Батлагдсан орон тоо 2025 оны тушаал	Сангийн яамны хянасан тоо	Цалингийн сан 2026 он төсөл	Сангийн яамны хянасан тоо зөрүү	2026 оны цалин СЯ хянасан /сая.төг/	2026 оны цалингийн зардал төслөөр /сая.төг/	Цалингийн зөрүү СЯ-ны хянасан тоо 2026 оны төсөл /сая.төг/
		3	4	5	=4-5	6	7	=6-7
1	Засаг даргын тамгын газар	87	70	87	-17	2896.6	3383.4	-486.8
2	Санхүүгийн хяналт, аудитын алба	10	6	9	-3	327.3	417.9	-90.6
3	Сум дундын ойн анги	9	5	9	-4	154.0	268.8	-114.8
4	Орон нутгийн өмчийн газар	7	7	10	-3	302.3	339.3	-37.0
5	Төрийн үйлчилгээний нэгдсэн төв	8	6	8	-2	244.3	270.3	-26.0
6	Худалдан авах ажиллагааны газар	6	6	8	-2	220.4	242.0	-21.6
7	Итгэдийн төлөөлөгчдийн хурал	16	11	18	-7	559.3	753.0	-193.7
8	Байгаль орчин, аялал	32	29	32	-3	876.4	966.9	-90.5

жуулчлалын газар								
<b>ТЕЗ-ийн харьяа байгууллагууд</b>	<b>175</b>	<b>140</b>	<b>181</b>	<b>-41</b>	<b>5580.6</b>	<b>6641.6</b>	<b>-1061.0</b>	
Сумдын ЗДТГ	478	413	476	-62				
Сумдын ИТХ	56	56	56	0				
<b>Нийт дүн</b>	<b>709</b>	<b>609</b>	<b>712</b>	<b>-103</b>				

Дээрх хүснэгтээс харахад ТЕЗ-ийн харьяа 8 байгууллагын цалингийн зардлыг Сангийн яамнаас 5,580.7 сая төгрөгөөр хянасан байхад 6,641.7 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

Сангийн яамны хянасан нийт төсөвт багтааж цалин, орон тоог хэвээр тооцоолж, зөрүү 1,061.0 сая төгрөгийг бусад урсгал зардлаас хасах байдлаар төлөвлөх нь байгууллагуудын үндсэн үйл ажиллагаа хэвийн үргэлжлэхэд эрсдэл үүсэх магадлалтай гэж үзэж байна.

ТЕЗ-ийн хэмжээнд 2026 онд төрийн албаны шинэчлэлийг хэрэгжүүлж, чиг үүргийн давхардлыг арилгаж, ажлын ачааллыг нягтруулж, цалингийн зардлыг тодорхой хэмжээгээр бууруулснаар орон нутгийн төсөвт ирэх ачааллыг багасгаж, төрийн үйлчилгээг ард иргэдэд хэвийн хэмжээнд, хүртээмжтэй хүргэх нь чухал байгаа учир **Төрийн аудитын байгууллагын зүгээс 500.0 сая төгрөгийн санхүүгийн бус үр өгөөжийг тооцож байна.**

## **2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй нийцсэн байдал:**

2.1. “Өвөрхангайд үйлдвэрлэв” төвийн дэмжлэгт 35.9 сая төгрөг төлөвлөсөн ч хариуцан ажиллуулах менежментийн гэрээний хугацаа 2026 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөр тасалбар болж байгаа тул зардлыг **17.9 сая төгрөгөөр бууруулах санал оруулж байна.**

2.2. Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зардлыг **100.0 сая төгрөгөөр бууруулах.**

Санхүүгийн тайлангийн завсрын аудитаар нөөц хөрөнгийн зардлаас журмын 2.1.1, 2.1.2-д заасан үндэслэлээр зарцуулалт бараг гараагүй байна. Дийлэнх зардал нь тэмдэглэлт баярын арга хэмжээ, шагнал, зочин төлөөлөгч хүлээн авах, сургалтын хоолны зардлыг санхүүжүүлсэн нь Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцэхгүй байна. Иймээс сургалт семинарыг цахим хэлбэрээр зохион байгуулж хоол, байр, албан томилолтын зардлыг хэмнэх, урьдчилж төлөвлөж болох зардлуудыг тусдаа эдийн засгийн ангилал дээр нь баталж зарцуулах бүрэн боломжтой тул нөөц хөрөнгийн зардлыг 100.0 сая төгрөгөөр бууруулах санал оруулж байна.

## **3. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардал, мэдээлэл, технологийн зардлын төлөвлөлт:**

Аймгийн ИТХ-ын төсвийн төсөлд Монгол улсын Засгийн газрын 2022 оны 404 дүгээр тогтоолыг үндэслэн дараах 2 зардлыг давхардуулан төлөвлөсөн байна. Үүнд:

- “Бараа үйлчилгээний бусад зардал”-д хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлыг /41 төлөөлөгч \* 5.0 сая төг/ 205.0 сая төгрөгөөр тооцож төлөвлөсөн
- “Сургалт дадлага, бэлтгэлийн зардал”-д 205.0 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Аймгийн ИТХ-ын 2024 оны санхүүгийн тайлангийн аудит, 2025 оны завсрын аудитаар төлөөлөгчдийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах зардлыг Засгийн газрын 404-р тогтоолоор батлагдсан журмын дагуу зарцуулаагүй тул 243.5 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлээд байна.

Энэхүү зардлыг илүү төлөвлөж, зарцуулснаар үр ашиггүй зардал бий болох, аудитаар өгсөн албан шаардлага хэрэгжихгүй байх эрсдэлтэй гэж үзэн аймгийн ИТХ-ын “Сургалт дадлага, бэлтгэлийн зардал”-г **205.0 сая төгрөгөөр бууруулах санал оруулж байна.**

## **4. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал:**

БОХНСАХ-ний зардлыг **119.0 сая** төгрөгөөр бууруулах: БОХНСАХ-ний зардалд 281.8 сая төгрөг төлөвлөсөн боловч дараах арга хэмжээнүүдийг төлөвлөхдөө зардлын тооцоолол байхгүй, хаана ямар ажил хийгдэх нь тодорхойгүй, хууль журамд нийцээгүй, хэрэгжүүлэх арга хэмжээний газар шийдэгдээгүй байгаа зэрэг нь орон нутгийн төсвийг төлөвлөх холбогдох хууль, журам, төсвийн төлөвлөлтөд баримтлах удирдамжид заасан шалгуурт нийцэхгүй байгаа тул 119.0 сая төгрөгөөр бууруулах санал оруулж байна.

- Ус хуримтлуулах хөв цөөрөм байгуулах, голын голдирлыг шулуутгах зураг төсөв хийлгэх, хөв цөөрмийн ашиглалтыг сайжруулах 30,0 сая төгрөг -Хаана, ямар ажил хийх нь тодорхойгүй,
- Байгаль орчны багц хууль, тогтоомж, дүрэм журам, шийдвэрийн хэрэгжилтийг хангах, хяналт, шалгалт, тооллого судалгааны ажил зохион байгуулах 15,0 сая төгрөг-Зардлын тооцоолол байхгүй
- Байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, шалгалт явуулахад шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах 19,0 сая төгрөг-Зардлын задаргаа байхгүй, нийгмийн асуудал шийдвэрлэх заалт журамд тусгагдаагүй
- Хөрсний доройтол, цөлжилтөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Арвайхээр суманд Байгаль орчны газрын нэрэмжит цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлыг эхлүүлэх 50.0 сая төгрөг-Газрын асуудал шийдэгдээгүй, зардлын тооцоолол байхгүй
- Ан амьтны амьдрах орчныг сайжруулах зорилгоор нэн ховор, ховор амьтанд зориулж хөв цөөрөм байгуулах 5.0 сая төгрөг- Хийх ажлын төсөв, тооцоолол байхгүй.

#### САНАЛ: Нийт бууруулах боломжтой зардлын хэмжээ 441.9 сая төгрөг

1. “Өвөрхангайд үйлдвэрлэв” төвийн дэмжлэгт 35.9 сая төгрөг төлөвлөсөн ч хариуцан ажиллуулах менежментийн гэрээний хугацаа 2026 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөр тасалбар болж байгаа тул зардлыг **17.9 сая** төгрөгөөр бууруулах
2. Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зардлыг **100.0 сая** төгрөгөөр бууруулах.
3. Аймгийн ИТХ-ын “Сургалт дадлага,бэлтгэлийн зардал”-с **205.0 сая** төгрөгөөр бууруулах
4. БОХНСАХ-ний зардлыг **119.0 сая** төгрөгөөр бууруулах

#### БҮЛЭГ 4. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ НЬ ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ЖУРМЫН ЗААЛТТАЙ НИЙЦЭХГҮЙ БАЙНА.

Аймгийн ОНХС-аас 2026 онд 10 ТАХ, Автозамын сангийн хөрөнгө оруулалтаар 2 ТАХ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ төлөвлөөгүй байна. Үүнд:

Хүснэгт 10. Аймгийн 2026 онд ОНХС, авто замын сангаас төлөвлөсөн ТАХ

№	Хөрөнгө оруулалтын төрөл	ТАХ тоо		Нийт төсөвт өртөг	2026 онд санхүүжих дүн
		Шилжих	Шинээр эхлэх		
1	ОНХС	2	8	4,876.77	4,254.09
2	Автозамын сан	1	1	1,915.00	1,115.00

## Хүснэгт 11. 2023-2025 оны орон нутгийн хөрөнгө оруулалтын тоон үзүүлэлт /сая.төг/

№	Хөрөнгө оруулалтын нэр төрөл	2023 оны батлагдсан төсөв		2024 оны батлагдсан төсөв		2025 оны батлагдсан төсөв	
		ТАХ-ний тоо	Санхүү -жилт	ТАХ-ний тоо	Санхүү -жилт	ТАХ-ний тоо	Санхүү -жилт
1	Аймгийн орон нутгийн төсөв, их засвар	23	1,660.00	43	3,537.7	26	4,301.24
2	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	47	6,446.13	18	6,194.8	17	6,470.20
3	Автозамын сан	9	718.70	6	833.0	4	1,132.00
<b>НИЙТ ДҮН</b>		<b>79</b>	<b>8,824.83</b>	<b>67</b>	<b>10,565.5</b>	<b>47</b>	<b>11,903.44</b>

/Эх сурвалж-Аудитын тайлан, СТСХ, ХБТХОХ -ийн ажлын баримтаас/

Дээрх хүснэгтээс харахад орон нутгийн хөрөнгө оруулалт өмнөх онуудад тогтмол өсөлттэй байсан бол 2026 онд төсвийн санхүүжилт буурч байгаатай холбоотой хөрөнгө оруулалт харьцангуй буурч төлөвлөгджээ.

#### 4.1. Орон нутгийн хөгжлийн сан

Төсвийн төсөлд тусгасан аймгийн ОНХС-аас хэрэгжүүлэх ТАХ-д санал, дүгнэлт гаргахад Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3<sup>3</sup>, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан<sup>4</sup> “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын заалтуудыг шалгуур болгон авч үзсэн.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 2026 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 12 ТАХ-ний иргэдээс цахимаар авсан дүнг хэлэлцэж, Засаг даргын зөвлөл ээлжит 15 дугаар хуралдаанаар хэлэлцэн, эрэмбэлж 7 ТАХ-г төсвийн төсөлд оруулсан байна.



#### АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аймгийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд дараах ТАХ тусгагдаагүй байна. Үүнд:

- Арвайхээр сумын цахилгаан эрчим хүчний уналттай гэр хорооллуудад 0.4кВ цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, РП барих замаар цахилгаан эрчим хүчний хангамжийг сайжруулах–2,103.65 сая төгрөг
- Бат-Өлзий сум Орхоны хүрхрээ орчмын угтах орчны тохижилт - 400.0 сая төгрөг
- Арвайхээр сум 13 дугаар багийн Дөл хорооллыг борооны ус болон үерийн ус зайлуулах байгууламжтай болгох-212.0 сая төгрөг
- Төсвийн хөрөнгө оруулалтаар 2027 онд баригдах барилга байгууламжийн зураг төсөв боловсруулах–500.0 сая төгрөгийн ТАХ нь аймгийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловч аймгийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд

<sup>3</sup> 60.3.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно:

60.3.1.орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ.

60.3.2.улс төрийн нам, төрийн бус байгууллагын зарлага;

60.3.3.үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам, ойн арга хэмжээ, шашны зан үйлийн болон ёслолын зардал;

60.3.4.нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа;

60.3.5.зээл олгох, санхүүгийн үр дагавар бүхий баталгаа гаргах, хохирлыг нөхөн төлөх үүрэг авах;

60.3.6.орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ.

<sup>4</sup> Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.7. Энэ зүйлийн 4.6-д зааснаар ОНХС-ийн хөрөнгийг зарцуулах зөвшөөрөхгүй зардалд дараах хамаарах ба үүгээр хязгаарлагдахгүй: 4.7.3-д “нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа”, 4.7.5-д “Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ”.

тусгагдаагүй Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаал "ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ"-ын 4.1.1-д "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх;" гэж заасантай нийцэхгүй байна.

Батлагдсан зураг, төсөвгүй ТАХ-ний жагсаалт:

- Иргэдийн саналаар 1-т эрэмблэгдсэн, нэн тэргүүний ач холбогдолтой ТАХ боловч батлагдсан зураг төсөвгүй, төлөвлөлтийн шаардлага хангаагүй - Арвайхээр сумын цахилгаан эрчим хүчний уналттай гэр хорооллуудад 0.4 КВ цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, РП барих замаар цахилгаан эрчим хүчний хангамжийг сайжруулах ажил 2,103.65 сая төгрөгийн төсөвт өртөгтэй;
- Бат-Өлзий сум Орхоны хүрхрээ орчмын угтах орчны тохижилтын ажил 400.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлууд нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-д "Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.", Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4.1.3-д "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон байх"; гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Батлагдсан төсвөөс зөрүүтэй дүнгээр төлөвлөсөн ТАХ-ний жагсаалт:

- Баяр наадмын зардал 200 сая төгрөгөөр төлөвлөжээ. Энэ нь Засгийн газрын 2010 оны "Жишиг хэмжээг шинэчлэн тогтоох тухай /Наадмын санхүүжилт/" 271 дүгээр тогтоолын "Үндэсний их баяр наадмын арга хэмжээнд зориулан төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээг аймагт 10.0 (арван) сая төгрөг, суманд 5.0 (таван) сая төгрөг байхаар тус тус тогтоож, бөх, уяач, харваачдад төсвөөс олгох бай, шагналын жишиг хэмжээг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай" гэсэн заалт зөрчигдсэн байна.
- "Арвайхээр хотод баригдаж байгаа 30 МВт дулааны станцын 2 дугаар хэлхээний шугам сүлжээг эцсийн хэрэглэгч буюу айл өрх, албан байгууллагын шугам сүлжээнд холбох болон горим тохируулгын ажил"-г 2020 онд хийгдсэн 178.99 сая төгрөгийн төсвийг үндэслэн 200.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн.
- "Арвайхээр сум 13 дугаар багийн Дөл хорооллыг борооны ус болон үерийн ус зайлуулах байгууламжтай болгох" ажил 2023 онд батлагдсан зураг, 2024 онд батлагдсан төсөвтэйгээр 212.0 сая төгрөгөөр төсөвлөгдсөн байна.

Жишиг үнэ, тариф, татвар хураамж, инфляцын түвшний өөрчлөлттэй холбоотой батлагдсан төсвийг шинэчлэх шаардлагатай бөгөөд шууд үнийн дүнг өсгөн тавих боломжгүй юм. Төсөвт өртгийг бодит тооцоололгүй төлөвлөснөөс ТАХ-ний чанар байдал, цаашид гарах үр өгөөжид сөргөөр нөлөөлнө.

Төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг магадлалаар баталгаажсан зураг, төсвийн дүнд үндэслэхгүйгээр төлөвлөж, төсөвт тусгах нь төсөвт өртөг нэмэгдэх, хэрэгжилт удаашрах эрсдэлийг дагуулж байна.

## Хүснэгт 12. Аймгийн ОНХС-с хэрэгжүүлэх “Төсвийн хөрөнгө оруулалтаар 2027 онд баригдах барилга байгууламжийн зураг төсөв боловсруулах” ажлын задаргаа

№	Ажлын нэр	Гэрээний дүн	Төсөвлөсөн дүн	Зөрүү	Тайлбар
1	Зүүнбаян-Улаан сумын төв доторх 3.4 км хатуу хучилттай авто замын төсөл	29.0	29.0	-	Ихэр мөнх ХХК шалгарч гүйцэтгэж байгаа
2	Зүүнбаян-Улаан сумын Хүүхдийн зуслангийн барилга	0	80.0	-	2026 онд хийгдэнэ
3	Хархорин сумын Номын хүрдэн ЕБС-ийн 250 хүний суудалтай спорт заал	39.0	40.0	1.0	Дизкон ХХК шалгарч гүйцэтгэж байгаа
4	Баруунбаян-Улаан сумын ЕБС-ийн 250 хүний суудалтай спорт заал	39.0	40.0	1.0	Дизкон ХХК шалгарч гүйцэтгэж байгаа
5	Хайрхандулаан сумын ЕБС-ийн гадна биеийн тамирын талбай	0	20.0	-	Дизкон ХХК -тай гэрээ байгуулах шатанд явж байгаа
6	Сант сумын төвийн хатуу хучилттай авто зам	0	50.0	-	2026 онд хийгдэнэ
7	Арвайхээр сумын Шинэ суурьшлын бүсэд баригдах 640 хүүхдийн сургуулийн барилга	119.3	120.0	0.7	Зэд прожект ХХК шалгарч гүйцэтгэж байгаа
8	Арвайхээр сумын Хөдөө аж ахуйн туршилт, судалгаа, малын үржил селекцийн төв	0	80.0	-	Тендер зарлагдах шатанд
9	Арвайхээр сумын Хүүхдийн 160 ортой дотуур байрын барилга	0	41.0	-	2026 онд хийгдэнэ
	<b>Нийт дүн</b>		<b>500.0</b>	<b>2.7</b>	

Аймгийн ОНХС-аас хийгдэх 500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 зураг төсвөөс 4 нь гэрээ хийгдсэн, тендер зарлагдах 1, гэрээ байгуулах шатанд 1, 2026 онд хийгдэх 3 төлөвлөсөн байна. Гэрээ хийгдсэн 4 зургийн ажлын үнээс 2.7 сая төгрөгийн зөрүүтэй үүсэж байна.

**САНАЛ: ОНХС-ийн хөрөнгө оруулалтаас нийт 592.7 сая төгрөгийн зардлыг бууруулах.**

- Баяр наадмын зардлыг жишиг хэмжээнд нийцүүлэн 190.0 сая төгрөгөөр бууруулах.
- Төлөвлөлтийн шаардлага хангаагүй Бат-Өлзий сум Орхоны хүрхрээ орчмын угтах орчны тохижилтын ажлыг 400.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлууд батлагдсан зураг төсөвгүй байна.
- Төсвийн хөрөнгө оруулалтаар 2027 онд баригдах барилга байгууламжийн зураг төсөв боловсруулах ажлын төсөвт өртгөөс гэрээний үнийн дүнгийн зөрүү 2.7 сая төгрөгийг бууруулах.
- “Арвайхээр хотод баригдаж байгаа 30 МВт дулааны станцын 2 дугаар хэлхээний шугам сүлжээг эцсийн хэрэглэгч буюу айл өрх, албан байгууллагын шугам сүлжээнд холбох болон горим тохируулгын ажил”, “Арвайхээр сум 13 дугаар багийн Дөл хорооллыг борооны ус болон үерийн ус зайлуулах байгууламжтай болгох” ажлуудыг шинэчилсэн төсөвт тулгуурлан батлах.

**4.2. Авто замын сан**

Төсвийн төсөлд тусгасан Авто замын сангаас хэрэгжүүлэх ТАХ-д санал, дүгнэлт гаргахад Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1<sup>1</sup>, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3, Сангийн Сайдын 2019 оны 312 дугаар тушаалаар батлагдсан “Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам”-ын заалтуудыг шалгуур болгон авч үзсэн. Авто замын сангаас 2026 онд дараах 2 ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

*Хүснэгт 13. Аймгийн Автозамын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-ний жагсаалт*

№	Төсөл арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	2026 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
<b>Шилжих хөрөнгө оруулалт</b>					
1	Арвайхээр сумын төвийн авто замын шинэчлэл, өргөтгөл	2025	2026	945,608.6	145,608.6
	<b>Дүн</b>				<b>145,608.6</b>
<b>Шинээр эхлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ</b>					
1	Орон нутгийн автозамын засвар, шинэчлэл	2026	2026	969,391.4	969,391.4
	<b>Дүн</b>			<b>1,915,000.0</b>	<b>1,115,000.0</b>

Дээрх 2 ТАХ нь баталдсан тооцоо судалгаатай хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн шаардлага хангасан байна.

## ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс болон аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Аймгийн 2026 оны төсвийн төслийг Орон нутгийн ТЕЗ нарын 2026 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамж; төсвийн төслийн танилцуулгыг Төсвийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.2.-д заасны дагуу тус тус бүрэн боловсруулаагүй байна.
2. Орон нутгийн орлогыг төлөвлөхдөө татварын бус орлого буюу торгуулийн орлогын дутуу; газрын төлбөр, үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын авлагуудыг тусгаагүй, орлого нэмэгдэх зарим боломжуудыг тооцоолоогүй /орхигдуулсан/ байна.
3. Зардлыг төлөвлөхдөө аудитаар илэрсэн нийтлэг алдаа зөрчлийг харгалзан үзэж байх шаардлагатай бөгөөд санхүүгийн тайлангийн завсрын аудитаар /2025/ илэрсэн зөрчилд үндэслэн Засаг даргын нөөц хөрөнгийн зардал, аймгийн ИТХ-ын төсвийн “Сургалт дадлага, бэлтгэлийн зардал”-аас үр ашиггүй зардал бий болох эрсдэлтэй гэж үзэн зардал бууруулах саналыг өгсөн. Мөн Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас хэрэгжүүлэх зарим ажлууд зардлын тооцоолол байхгүй, хаана ямар ажил хийгдэх нь тодорхойгүй, хууль журамд нийцээгүй байна.
4. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг магадлалаар баталгаажсан зураг, төсвийн дүнд үндэслэхгүйгээр төлөвлөж, төсөвт тусгах нь төсөвт өртөг нэмэгдэх, хэрэгжилт удаашрах эрсдэлийг дагуулж байна.

## ЗӨВЛӨМЖ

### Аймгийн Засаг дарга О.Пүрэвдорж танаа:

- Аймгийн төсвийн төслийг Сангийн яамнаас баталсан орон нутгийн ТЕЗ нарын төсвийн төсөл бэлтгэх удирдамжийн дагуу; төсвийн төслийн танилцуулгыг Төсвийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.2.-д заалтад нийцүүлэн бэлтгэж байх.
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих ТАХ-г Төсвийн тухай хууль болон Төрийн хэмнэлтийн тухай хууль, бусад холбогдох дүрэм журамд нийцсэн, шаардлага хангасан төслүүдийг төлөвлөж байх; өмнөх онуудад хийгдсэн зураг төсөвтэй ажлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөхдөө шинэчилсэн, баталгаажсан төсөвт үндэслэх.

### Аймгийн Засаг дарга О.Пүрэвдорж, Татварын газрын дарга Н.Эрдэнэсүвд танаа:

- Татварын орлогын бүрдүүлэлт, ногдуулалтад хяналт тавьж, биелэлтийг хангахын зэрэгцээ хуримтлагдсан авлагыг барагдуулах нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж авлагыг 40.0-өөс дээш хувиар бууруулан ажиллах;

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2025 оны 12 дугаарын 25-ны дотор ирүүлнэ үү. Зөвлөмжийн биелэлтийг тооцож, нотлох баримтыг хангуулан 2026 оны 11 дүгээр сарын 01-ний дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### Хавсралт-1

№	Сум, дүүрэг	Эзэмшигчийн нэр	Талбайн нэр	Тусгай зөвшөөрлийн төрөл	Ашигт малтмалын төрөл	Олгосон огноо	Дуусах он	Талбайн хэмжээ /га/	Газрын төлбөр ногдуулаагүй дүн /сая.төг/
1	Зүүнбаян-Улаан	Эм Эс бэл майнинг	Өртөнт, Нарийн жалга	Ашиглалт	Алт	1997.06.12	2027.06.12	40.6	3.66
2	Нарийнтээл	Империо майнинг	Үзүүрт	Ашиглалт	Алт	2022.08.07	2052.08.07	963.8	86.74
3	Тарагт	Галт-Үнэг	Сүртийн ам	Ашиглалт	Алт	2018.05.31	2048.05.31	309.3	27.84
4	Төгрөг	Боржигт	Хэцүү цав	Ашиглалт	Хайлуур жонш	2006.10.18	2036.10.18	193.7	17.43
5	Хайрхандулаан	ЭТА энжи	Цоорхой   Баруун урд сайр	Ашиглалт	Алт - Шороон	2024.05.15	2054.05.15	165.5	14.89
6	Уянга	Ундран ариажих баялаг ХХК	Хайрга-1	Ашиглалт	ТТАМ	2024.10.31	2039.10.31	118.86	19.02
7	Тарагт	Өв Идэр ХХК	Их булаг	Ашиглалт	ТТАМ	2024.01.25	2039.01.25	33.3	5.33
8	Тарагт	Зул буян ундрах ХХК	Их булаг-1	Ашиглалт	ТТАМ	2023.07.17	2038.07.17	32.43	5.19
9	Зүүнбаян-Улаан	Баяндөхөмийн хурд	Өвдөг худаг	Ашиглалт	ТТАМ	2022.02.21	2037.02.21	24.85	3.98
10	Зүүнбаян-Улаан	Арвайн дэвшил ХХК	Өвдөг худаг	Ашиглалт	ТТАМ	2022.03.22	2037.03.22	31.54	5.05
11	Бат-Өлзий	Мотор сервис ХХК	Зам дагуу	Ашиглалт	ТТАМ	2023.03	2025.1	3.3	0.53
12	Хужирт	Өндөр Сант Хайрхан ХХК	Зам дагуу	Ашиглалт	ТТАМ	2022.09	2025.1	20.6	3.30
13	Хужирт	Өндөр Сант Хайрхан ХХК	Зам дагуу	Ашиглалт	ТТАМ	2024.09	2027.08	29.9	4.78
14	Бүрд	Чайна роуд энд бридже корпорашн	Зам дагуу	Ашиглалт	ТТАМ	2023	2024	0.5	0.08
15	Тарагт	Хулжийн голын зам ХХК	Зам дагуу	Ашиглалт	ТТАМ	2024.07	2025.11	8.9	1.42

Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газрын сайт болон legalinfo.mn

**Хавсралт-2**

Сумдын үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын 2018-2025 оны төлөөгүй өрийн судалгаа

Д/д	Сумын нэр	2018-2022 он			2023-2025 он		
		Нэхэмжлэхийн дүн	Барагдуулалтын дүн	Өрийн үлдэгдэл	Нэхэмжлэхийн дүн	Барагдуулалтын дүн	Өрийн үлдэгдэл
1	Арвайхээр	2,728.6	2,563.3	165.3	1,821.7	1,460.4	361.3
2	Баруунбаян-Улаан	2.3	2.2	0.1	16.1	14.4	1.6
3	Бат-Өлзий	10.7	6.9	3.8	51.9	32.5	19.4
4	Баян-Өндөр	2.9	2.9	-	12.1	11.5	0.5
5	Баянгол	5.4	5.3	0.1	16.5	15.0	1.5
6	Богд	6.7	5.7	1.0	34.3	30.6	3.7
7	Бүрд	2.5	2.5	-	10.7	8.9	1.8
8	Гучин-Ус	3.5	3.1	0.4	20.7	18.3	2.5
9	Есөнзүйл	3.5	3.4	0.1	10.8	9.0	1.8
10	Зүүнбаян-Улаан	3.3	3.3	0.0	9.3	8.7	0.6
11	Нарийнтээл	6.8	6.8	0.0	64.3	63.5	0.8
12	Өлзийт	2.7	2.3	0.4	15.1	13.4	1.7
13	Сант	4.0	4.0	-	16.8	15.4	1.4
14	Тарагт	2.7	2.4	0.3	19.0	13.9	5.1
15	Төгрөг	3.6	3.6	-	18.1	18.0	0.1
16	Уянга	13.9	13.5	0.4	59.3	49.5	9.8
17	Хайрхандулаан	4.0	3.9	0.1	23.7	20.6	3.0
18	Хархорин	139.4	136.7	2.6	562.7	385.0	177.7
19	Хужирт	234.3	221.3	13.0	759.2	435.3	323.9
	<b>Нийт</b>	<b>3,180.8</b>	<b>2,993.3</b>	<b>187.6</b>	<b>3,542.2</b>	<b>2,623.9</b>	<b>918.3</b>

## ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



### ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 11 сарын 25 өдөр

Дугаар *118*

Арвайхээр сум

#### Нийцлийн аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.3 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн А/102 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1.4 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн **ТУШААХ нь:**

1. “Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд санал дүгнэлт өгөх” нийцлийн аудитын тайланг /ӨВА-2025/07-14-ШТА-НА/ хавсралтаар баталгаажуулсугай.
2. Нийцлийн аудитын тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, аймгийн Засаг даргад хүргүүлж ажиллахыг ахлах аудитор (Ө.Ринчинмядаг)-д үүрэг болгосугай.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор, зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллан, биелэлтийг 2026 оны 11 дүгээр сарын 01-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлэхийг аймгийн Засаг дарга (О.Пүрэвдорж)-д зөвлөсүгэй.
4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аудитын менежер (П.Хорлоосүрэн), ахлах аудитор (Ө.Ринчинмядаг) нарт даалгасугай.
5. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 30 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитор (Р.Энхзүл)-д үүрэг болгосугай.



О.БАТЖАРГАЛ

D:\Audiitiin gazar\Baiguullagiin dotood barimt\Tushaal

8225010078

**Утас:** +976 7032-3253, 70323-833, 7032-3108

**Цахим шуудан:** [uvurkhangai@audit.gov.mn](mailto:uvurkhangai@audit.gov.mn)

**Цахим хуудас:** [www.audit.mn](http://www.audit.mn)

**Хаяг:** Монгол улс, Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, Нутгийн удирдлагын ордон